



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/61

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 1 аж ахуйн нэгж, 3 иргэний нийт 0.2778га /2778м²/ газрыг хавсралтад дурдсанаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 23-ны өдрийн
А/61 дүгээр захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Эрх шилжүүлж байгаа иргэний овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэний овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Шарнууд овгийн Очирбат Эрдэнэбат /РЭ63072613/	Буриад овгийн Мөнхбат Тогтохдэмбэрэл /РЭ67050176/	6712013063	Гэр орон сууцны хашааны	8-р баг Геодезийн байр	121	15	Аймгийн Засаг даргын 2014.11.18-ны өдрийн А/419 дүгээр захирамжийн хавсралтын 7 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	Их мэргэд овгийн Лхамсүрэн Амартүвшин /МА71102701/	Гал овгийн Мөнхбаяр Нарантуяа /РЛ93091501/	6712015857	Худалдаа, нийтийн үйлчилгээ	7-р баг 26-21 тоот	39	7	Аймгийн Засаг даргын 2014.04.17-ны өдрийн А/149 дүгээр захирамжийн хавсралтын 7 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	Шарнууд овгийн Ширэндэв Эрдэнэхүү /РЮ57081016/	"Хөвсгөл трэйвел" ХХК /РД:2626993/	6712016103	Үйлчилгээтэй орон сууц	8-р баг Согоот-2 208 тоот	2188	28	Аймгийн Засаг даргын 2010.03.05-ны өдрийн А/65 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр, газрын зориулалт өөрчлөх
4	"Энгэр мөрөн" ХХК /РД:4127552/	Хатгин овгийн Даваадорж Энхцацралт /РЮ90050113/	6712008687	Үйлдвэрлэл, үйлчилгээ	8-р баг Даваадорж -3 308 тоот	430	22	Аймгийн Засаг даргын 2011.09.22-ны өдрийн А/300 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 2778м²

-----оОо-----